



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/03

Бор-өндөр сум

**Шинэ ажилтан сонгон шалгаруулах
журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5, Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Засгийн газрын 2022 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 352 дугаар тогтоол, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бор сумын Нэгдсэн эмнэлэгт шинээр ажилд орж буй эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтныг сонгон шалгаруулах “Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг тушаалын хавсралтаар баталсугай.

2. Тус эмнэлэгт төрийн үйлчилгээний албан тушаалд томилохдоо ажлын байрны шаардлагад нийцүүлэн боловсрол, мэргэжил, мэдлэг туршлага ур чадвараар нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, шударга ил тод зарчмыг баримтлан зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /Б.Халиун/-д даалгасугай.

3. Энэхүү журмыг 2025 оны 01 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

А.БАТБААТАР

